



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/07

Баянтал сум

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,
төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж,
төлөвлөх, зөвлөгөө өгөх ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр 2023 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх, зөвлөгөө өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Худалдан авах ажиллагаа

хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Санхүү албаны дарга

Байгаль орчин хамгаалагч

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Ахмадын хорооны дарга

Иргэний төлөөлөл

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх баг, хорооны "Иргэдийн нийтийн хурлаас" ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг бэлтгэн сумын Засаг даргын зөвлөлд 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай..

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/13 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

Г.АНХБАЯР



ГС ВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/08

Баянтал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нэр бүхий 2 иргэнд Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хавсралтад заасан газрын байршилд 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрх олгосугай.

2.Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын төлбөр тооцох, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Г.АНХБАЯР



 Сумын Засаг даргын 2022 оны
 08 дугаар сарын 08-ны өдрийн
 108 дугаар захирамжийн хавсралт

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшиж байгаа иргэдийн нэрсийн жагсаалт

дд	Газар эзэмшигчийн					Эзэмшсэн газрын		
	Ургийн овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Хаяг, байршил	Зориулалт	Хэмжээ /м ² /
1	Баяуд	Ганбаатар	Батзул	ЕЙ89081713	2-р баг	2-р баг Өртөө -5-503 тоот	ГБХ	700
2	Баяуд	Ганбаатар	Отгонзул	ЦХ97012311	2-р баг	2-р баг Өртөө-6-605 тоот	ГБХ	700

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 1109

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/57 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Амжиргааны түвшин доогуур орлоготой өрхүүдэд нийгмийн олон талт үйлчилгээг цогцоор нь хүргэж, орлого багатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Гишүүд:

Э.Эрхэмбаатар (Орлогч дарга)

В.Гантуяа (Тамгын газрын дарга)

Д.Цэрэнням (Ерөнхий

боловсролын сургуулийн захирал)

Ч.Отгонцэцэг (Цэцэрлэгийн

эрхлэгчийн үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Х.Энхжаргал (Соёлын төвийн
эрхлэгч)

Б.Бямбасүрэн (Эрүүл мэндийн
төвийн дарга)

А.Батжаргал (Талын Илч
ОНӨААТҮГ-ын дарга)

Н.Мөнгөнцэцэг (1 дүгээр багийн
Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (2 дугаар багийн
Засаг дарга)

С.Оюунтүлхүүр (Хөдөө аж ахуйн
тасгийн мэргэжилтэн)

421220036


Нарийн бичгийн дарга:

Г.Болормаа (Хөдөлмөр эрхлэлт,
халамжийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Э.Буянтогтох (Нийгмийн бодлого
хариуцсан мэргэжилтэн)

О.Жамъяншарав(Ерөнхий
боловсролын сургуулийн нийгмийн
ажилтан)

2. “Нэг өрх- нэг ажлын байр” арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д болгосугай.

ДАРГА  Г.АНХБАЯР

